



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

В.ХАДХҮҮ

БАТЛАВ: ЗООНЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ЗАХИРАЛ *[Signature]* Н.ЦОГБАДРАХ

ТТ35150 № 9092005

Улаанбаатар хот

№ 026

Энэхүү гэрээг нэг талаас БГД 5-р хороо Амин эрдэнэ эмнэлэг 25 тоот байрладаг “ОНОЛАБ” ХХК / цаашид Нийлүүлэгч гэх/-ийг төлөөлж Борлуулалтын менежер ажилтай Г.Баярням, нөгөө талаас Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрладаг Зоонозын өвчин судлалын үндэсний төв/цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж Аж ахуйн менежер ажилтай Ц.Булганхангай нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан дор дурдсан нөхцлөөр 2016 оны 06 дугаар сарын 28 өдөр энэхүү гэрээг /цаашид Гэрээ гэх/ хэлэлцэн тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- Нийлүүлэгч нь гэрээгээр тохиролцсоны дагуу ВК-75 маркын автоклав нийлүүлж, захиалагч тал гэрээнд заасан нөхцөл, хугацаанд үнийг төлнэ.
- Талууд хамтын ажиллагаанд харилцан ашигтай байх, эрх тэгш байх, тогтвортой байдлын зарчмыг баримтална.
- Гэрээний зүйлийн үнэ: 14,160,000(Арван дөрвөн сая нэг зуун жаран мянган төгрөг) /НӨАТАтвар орсон/
- Захиалагч нь гэрээний үнийн дүнгийн 70%-ийг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор багтаан нийлүүлэгчид шилжүүлнэ.
- Гэрээний бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээлгэн өгснөөс хойш ажлын 10 хоногийн дотор захиалагч нь нийлүүлсэн тухайн барааны үлдэгдэл үнийн дүн болох 30%-ийг нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
- Гэрээний зүйл хүлээн авах хаяг: СХД 20 хороо ЗӨСҮТөвийн өөрийн байранд

Хоёр. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- Нийлүүлэгч нь хавсралтанд дурдсан барааг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 25 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэн өгнэ.
- Гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийн үнийг валютын ханшны өөрчлөлт, түүхий эдийн импортоор орж ирэх үнэ зэргээс хамаарч өөрчлөх бол хүлээн авагчийн талд ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- Хүлээн авагчаас гэрээний төлбөрийг энэхүү гэрээний 4-р зүйлд заасан журмын дагуу төлөхийг шаардах.
- Хүлээн авагчийн гэрээгээр тохиролцсон газар тоног төхөөрөмжийг хүргэнэ.
- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Хүлээн авагчаас шаардах.

Гурав. Хүлээн авагчийн эрх, үүрэг

- Захиалгын дагуу нийлүүлэгдэн ирсэн барааг холбогдох бичиг баримтын хамт шуурхай хүлээж авна.

- 3.2 Чанарын талаархи гомдлыг хүлээн авснаас хойш 2 хоногийн дотор нийлүүлэгчид тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.3 Энэхүү гэрээний 4-р зүйлд заасан журмын дагуу төлбөрөө төлөх
- 3.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Нийлүүлэгчээс шаардах.

Дөрөв. Төлбөр хийх журам

- 4.1. Тоног төхөөрөмжийн үнийг нэхэмжилсэн нэхэмжлэх хүлээн авснаас хойш таван /5/ хоногийн дотор нийлүүлэгч талын дансанд шилжүүлсэн байна.
- 4.2. Төлбөрийг нийлүүлэгчийн ХАС БАНК дахь **5001055177** тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

Тав. Хариуцлага

- 5.1. Хүлээн авагч нь төлбөрийг Гэрээний 4 дүгээр зүйлд заасан журмын дагуу хугацаандаа шилжүүлээгүй хугацаа хэтэрсэн бол, тийнхүү хэтруулсэн өдрөөс хэтэрсэн хоног тутамд 0,2 хувийн алданги төлнэ.
- 5.2. Бусад хариуцлага : Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг (гэрээний үнийн дүн, алдангиас үл хамааран) хариуцна.
- 5.3. Хүлээн авагч нь тоног төхөөрөмжийг чанарын шаардлага хангасан гэж үзэн хүлээн авснаас хойшхи 3-гч этгээдийн өмнө хүлээх аливаа хариуцлагыг Нийлүүлэгч тал хариуцахгүй.

Зургаа. Хугацаа

- 6.1. Энэхүү гэрээний хугацаа гэрээ байгуулсан өдрөөс эхлэн **2016 оны 12 сарын 31** хүртэл байна.
- 6.2. Талуудын аль нэг нь гэрээг цуцлах саналтай бол энэ тухайгаа 2 сарын өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

Долоо.Бусад

- 7.1. Гэрээний талаар гарсан маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдэж эс чадваас Монгол улсын шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.
- 7.2. Энэхүү гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд тал тус бүр 1 /нэг/ хувийг хадгална. Хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй.
- 7.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 7.4. Гэрээний аль ч тал нөгөө талын бичгээр өгсөн зөвшөрөлгүйгээр энэ гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэн өгч болохгүй.
- 7.5. Энэ гэрээнд тодорхойлон заагаагүй асуудлыг шийдвэрлэхдээ талууд Монгол улсын иргэний хуулийн холбогдох заалтыг удирдлага болгоно.



“ОНОЛАБ” XXX-ийн

Борлуулалтын менежер:

Г.Баярням

Утас: 70007553 88114957

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн

Аж ахуйн менежер

..... Ц.Булганхангай

Хуулийн зөвлөх

..... Б.Ариухантөмөр

Утас: 70181022

Факс: 70282859

2016 оны 06-р сарын 28-ны өдрийн

026 тоот гэрээний Хавсралт

Нийлуулэх , материалын жагсаалт

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Автоклав ВК-75	ширхэг	1	14,160,000	14,160,000
		Нийт үнэ			14,160,000

ӨНӨЛДӨР ХХК ҮНİЙН САНАЛ

№	Тоног төхөөрөө мж	техникийн үзүүлэлт	Шир хэг	Үнэ
1	Автоклав	<p>Загвар: ВК-75-01 п/автомат</p> <p>Хансанусныдааралттайураарэмнээгийнпрактикхэрэглэ</p> <p>гдэгэдмматериал, баражиуутгана.</p> <p>Ариутгачийнундсэнэданиг, ариутгахкамер,</p> <p>хаалтгынъөмдөрчанараынээзвэрдэгтиганаарбутээсэн,</p> <p>усныхоолой,</p> <p>бохирыннэгдсэншугамгүйедашиглажболно.</p> <p>Багтаамж, дм3: 75</p> <p>Камерийнбагтаамж, дм3: 54</p> <p>Камерийндиаметр, мм: 400</p> <p>Ачаалахөндөр, мм: 785</p> <p>Хэмжээ, мм: 1100x570x755</p> <p>1 дэглэм (т өс - мин. - МПа): 132-20-0,2</p> <p>2 дэглэм (т өс - мин. - МПа): 120-45-0,11</p> <p>Суурилуулажчадал, кВт: 14</p> <p>Парогенераторынхүчинчадал, кг/ч уур: 15,87</p> <p>Хүчдэл, В: 380</p>	1	14.160,000